



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/171

Улаанбаатар хот

“Гаули ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг түр сэргээх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн цахимаар ирүүлсэн албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гишүүн “Гаули ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд түр сэргээсүгэй.
2. Дээрх хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.35-т “Зохицуулалттай этгээдийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд брокерийн компани зөвхөн харилцагчийн үнэт цаасны худалдах, худалдан авах захиалгыг биелүүлж болох бөгөөд харин өөрийн компанийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлэхгүй ба зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл шаардлагыг арилгахгүйгээр нэг сарын хугацаа өнгөрсөн нөхцөлд харилцагчийн захиалгыг биелүүлэх эрхийг түр зогсоож, харилцагчийг өөр брокерийн компаниар үйлчлүүлэх арга хэмжээг Хорооноос авч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг “Гаули ҮЦК” ХХК /Хан Гю Бун/-д үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг хаах ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт, шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1523030374